

МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Дархан-Уул аймаг дахь “Үр тариа хадгалах 36.0 мянган тонн багтаамжтай, төмөр бетон хийцтэй элеватор” худалдан авах үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнг хэлэлцсэн тухай

Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 49 тоот хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн хүрээнд ХХААХҮЯ, МУХБ, ТЭДС-гийн хамтарсан ажлын хэсэг ХХААХҮЯ-ны ТНБД-ын баталсан удирдамжийн дагуу “Дархан-Уул аймагт түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр үр тариа хадгалах 36.0 мянган тонн багтаамжтай, төмөр бетон хийцтэй элеватор худалдан авах үйл ажиллагаа”-нд хийсэн хяналт, шалгалтын дүнг танилцуулав.

1. Дархан-Уул аймагт газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах барих төсөл, арга хэмжээний төсвийг төлөвлөх, тендерийн баримт бичиг, техникийн даалгавар боловсруулах, тендер шалгаруулах явцад Төсвийн тухай хуулийн 14.2.3 дахь заалт, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 3.1.5 дахь заалт, 6.1. дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1, 27.3. дахь хэсэг 28.7.1. дэх заалт, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Монгол улсын Барилгын тухай хуулийн 15.1.1. дэх заалт, 13.2, 13.3, 13.5, 15.2, 16.2, 16.6. дахь заалтуудыг тус тус зөрчсөн байгаа тул уг худалдан авах үйл ажиллагаа, үйл ажиллагааг зохион байгуулсан **барилга угсралтын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны дарга, гишүүдийг холбогдох хуулийн байгууллагад хандаж шалгуулах** нь зүйтэй гэж дүгнэв. Энэ дүгнэлт нь дараах зөрчлүүдээр үндэслэгдсэн болно. Үүнд:

1.1 Тендерын баримт бичиг боловсруулахдаа ТООЗ 32.3(б)-д заасан “Ажил гүйцэтгэх хуваарь...”-г шинэ барилга байгууламж барих боломжит хугацаанаас богино хугацаа тогтоосон, ТООЗ 14.1-д заасан “Хамгийн доод шалгуур...”-г Дархан гурил тэжээл ХК-д зориулсан заалт оруулсан нь тендерт оролцогчид ижил тэгш өрсөлдөх боломжийг хязгаарласны зэрэгцээ хуучин байгууламж нийлүүлэх этгээдэд илт давуу байдал олгосон байна. Энэ үйлдэл нь нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1-дэх заалтыг зөрчсөн байна.

1.2 Тендерийг үнэлэхдээ тендерт оролцогчийн санхүүгийн чадавхийг бодитойгоор үнэлээгүй, түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон Тариалан эрхлэлтийг дэмжих санд өртэй байгааг харгалзан үзээгүйн улмаас 2013 оны санхүүгийн тайлангаар 5.3 тэрбум төгрөгийн авлагатай, 2.1 тэрбум төгрөгийн богино хугацаат өр, 3.1 тэрбум төгрөгийн урт хугацаат зээл, нийт 5.2 тэрбум төгрөгийн өр, төлбөртэй Дархан гурил тэжээл ХК-ийг шалгаруулж мөн хуулийн 27.3. дахь заалтыг зөрчсөн байна.

1.3 Тендерийг үнэлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28.7.1-д заасны дагуу үнийн зөрүүг залруулах үйл ажиллагаа хийхгүйгээр тендерт оролцогчийн санал болгосон үнийг шууд хүлээн зөвшөөрч гэрээний үнийг тогтоосон нь Төсвийн тухай хуулийн 14.2.3-д заасан төсвийг үр ашигтай удирдах тухай заалт, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5.1.1-д

заасан захиалагчийн саналаар эрх бүхий этгээдэд хандаж өнөөгийн үнэ цэнийг тогтоолгох тухай заалтыг тус тус зөрчсөн байна.

1.4 Ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжид хүн ажиллах тайтай нөхцөл, аюулгүй байдал бүрэн хангагдаагүй, барилга байгууламжийн зураг төсөл, төсвийн боловсруулалт, баталгаажилт, магадлал хийгдээгүй, газрын зөвшөөрөл авах, техникийн нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагаа зохих ёсоор зохион байгуулагдаагүй, холбогдох эрх бүхий байгууллагаас зайлшгүй авах шаардлагатай зөвшөөрлийг аваагүй байгаа нь тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Монгол улсын Барилгын тухай хуулийн 15.1.1. дэх заалт, 13.2, 13.3, 13.5, 15.2, 16.2, 16.6. дахь хэсгүүдийг тус тус зөрчсөн байна.

2. Тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулсан, гэрээний хэрэгжилтийг хянах, дүгнэх, барилга байгууламж хүлээн авах явцад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6 дахь хэсэг, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 3.1.5. дахь заалт, 6.1. дэх хэсгийг тус тус зөрчсөн байгаа тул **гэрээ байгуулах, дүгнэх, барилга байгууламжийг хүлээн авах, санхүүжилт олгох үйл ажиллагаанд оролцсон албан тушаалтнуудыг холбогдох хуулийн байгууллагад хандаж шалгуулах, ажлын хариуцлага алдсан албан тушаалтнуудад хууль тогтоомжийн дагуу захиргааны арга хэмжээ авах нь зүйтэй гэж дүгнэв.** Энэ дүгнэлт нь дараах зөрчлүүдээр үндэслэгдсэн болно. Үүнд:

2.1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Тухайлбал: Санхүүжилт хийхээр 6,400,000,000 төгрөгийн гүйцэтгэлийн анхан шатны баримт бүрдүүлэхдээ хуучин барилга, үл хөдлөх эд хөрөнгө эзэмших эрхийг шилжүүлэн авсан тухай баримт бүрдүүлсэн байна. Харин 1,600,000,000 төгрөгийн санхүүжилт хийхээр гүйцэтгэлийн анхан шатны баримт бүрдүүлэхдээ барилга, угсралтын ажил шинээр гүйцэтгэсэн тухай төсвийн тайлан, тооцоог хавсарган гүйлгээ хийсэн зөрчил гаргасан байна.

2.2. Гэрээ, сунгалтын хамт 2015 оны 7 дугаар сарын 1 өдөр дуусгавар болсон бөгөөд гэрээний хугацаа дууссан өдрөөс хойш 158 хоногийн дараа буюу 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдөр гэрээг дүгнэхдээ хугацаа хэтэрсэн хоногт алданги тооцоогүй байна. Үүнд: Гэрээний ерөнхий нөхцлийн 26.2 дахь заалтыг гэрээ дүгнэх шатанд хэрэгжүүлээгүйгээс 2015 оны 12 дугаар сарын 10 хүртэл 24-н долоо хоног буюу 1.6 тэрбум ($15,995,000,000 * 0.5\% * 24 = 1,919,400,000$ буюу гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй гэдэг нөхцөлөөр 1,599,500,000) төгрөгийн алдангийг тооцож аваагүй зөрчил гаргасан байна.

2.3 Мөн Үйлдвэр, хөдөө, аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/422 дугаар тушаалаар томилогдсон Улсын комиссын бүрэлдэхүүнд барилгын техникийн хяналтын улсын байцаагч оруулаагүй зөрчил гаргасан байна. Энэ хүрээнд Сангийн яамнаас 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 4-4/6843 тоот албан бичгээр ирүүлсэн барилгын техникийн хяналтын улсын байцаагч заавал ажиллуулах тухай шаардлагын дагуу 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр буюу ажлын нэг өдөрт багтаан барилгын техникийн улсын комиссын дүгнэлтийг нөхөн гаргуулсан нь үндэслэлгүй байна.

3 Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр нийлүүлэгдсэн 1982-1983 оны хуучин барилга, байгууламж нь ашиглалтаас гарсан зэргэлдээх байгууламжаас бүрэн

тусгаарлагдаагүйн улмаас хортон шавьж тархах, корпус хоорондын хоолой, шугам сүлжээгээр механик бохирдол дамжих эрсдэлтэй байгаа тул хүнсний зориулалттай улаан буудай нөөцлөн хадгалах боломж бүрдээгүй гэж дүгнэв. Энэ талаар Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлтүүд удаа дараа гарсан болно.

4 Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр нийлүүлэгдсэн 1982-1983 оны хуучин барилга, байгууламжийг 15,9 тэрбум төгрөгөөр үнэлж авсан нь өмнөх жилүүдэд худалдан авсан Төв аймгийн Угтаал, Булган аймгийн Булган суман дахь ижил хүчин чадалтай байгууламжийн үнэтэй харьцуулахад 3 дахин өндөр байгаа нь бодит өртөгөөс давсан хийсвэр үнэ тогтоож худалдаж авсан гэж дүгнэх үндэслэлтэй байна. Энэ үйлдэл нь Төсвийн тухай хуулийн 14.2.3-д заасан “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” тухай заалт, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5.1.1-д заасан “үнэлгээчинтэй харилцан тохиролцож үнэ цэнийг тогтоолгох” тухай заалтыг тус тус зөрчсөн тул **эрх бүхий хуулийн этгээдээр үнэлгээ хийлгэж бодит хохирлыг тогтоон шүүхэд нэхэмжлэл гарган хохирлыг барагдуулах** нь зүйтэй гэж дүгнэв.

5 Зарим байгууламжийн барилга угсралтын ажил бүрэн дуусаагүй, газар өмчлөх эрх нь шилжиж ирээгүй, ашиглалтад хүлээн авснаас хойш жил гаруй хугацаа өнгөрсөн хэдий ч хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл хангагдаагүй 15.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй барилга, байгууламжийг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр зөвхөн төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрийг үндэслэн Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн данс бүртгэлд тусгасан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3-д “Төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна” гэсэн заалтыг зөрчсөн байх тул **хүнсний улаан буудай ашиглах боломжгүй агуулахын барилга байгууламж болон суурилагдсан тоног төхөөрөмжийг Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн балансас хасуулах** арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах нь зүйтэй гэж шийдвэрлэв.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3. дахь заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. Дархан-Уул аймагт түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр үр тариа хадгалах 36.0 мянган тонн багтаамжтай, төмөр бетон хийцтэй элеватор худалдан авах гэрээт ажлыг хуулийн байгууллагад хандаж шалгуулахыг Хуулийн хэлтэс /Б.Батцэцэг/, Тариалан эрхлэлтийг дэмжих сан /В.Үнэнбат/ нарт үүрэг болгосугай.

2. Дархан-Уул аймагт түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр үр тариа хадгалах 36.0 мянган тонн багтаамжтай, төмөр бетон хийцтэй элеватор худалдан авах үйл ажиллагаагаар нийлүүлэгдсэн хуучин барилга байгууламж, шинээр суурилагдсан тоног төхөөрөмжүүдийн бодит үнэ өртөгийг эрх бүхий хуулийн этгээдээр тогтоолгож төсөвт учирсан хохирлыг шүүхэд нэхэмжлэл гарган барагдуулах ажлыг зохион байгуулахыг Хуулийн хэлтэс /Б.Батцэцэг/, Тариалан эрхлэлтийг дэмжих сан /В.Үнэнбат/ нарт даалгасугай.

3. Дархан-Уул аймагт түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр үр тариа хадгалах 36.0 мянган тонн багтаамжтай, төмөр бетон хийцтэй элеватор худалдан авах үйл ажиллагааны тендерын үнэлгээний хороо, гэрээ байгуулах, дүгнэх, барилга байгууламж

хүлээн авах ажлын хэсэгт ажилласан албан тушаалтнуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох асуудлыг судалж шийдвэрлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /Л.Баяртулга/-д үүрэг болгосугай.

4. Аудитын хорооны зөвлөмжийн хэрэгжилтийг хяналтад авч, биелэлтийг дотоод аудитын хороонд тайлагнахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Совд/-д үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, ДОТООД
АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА

П.СЭРГЭЛЭН